



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/417

Чойбалсан

Г Бруцеллёзын вакцинжуулалтыг зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.7.1, аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2.8, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/115 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1.Малын зооноз, архаг халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд бүх охин тугал, ишиг, хурганд 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зааврын дагуу зохион байгуулж, дүн мэдээг өдөр тутам аймгийн Мал эмнэлгийн газарт мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.Мал сүргээ зооноз, архаг халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж шаардлагатай хашаа хороо, хүн хүчээр хангаж ажиллахыг нийт малчид, мал бүхий иргэдэд тус тус үүрэг болгосугай.

3.Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар (Ч.Аюушмаа)-т Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ